



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар A/101

Улаанбаатар хот

**Байгууллагын тусламж, үйлчилгээний шуурхай
бэлэн байдлыг хангах тухай**

2020 оны 12 сарын 21-ний өдрийн А/226 дугаар Монгол улсын засгийн газрын тогтоол, Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1, "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/161 дүгээр тушаал, төвийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.1.17, 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ жилийн амралтын өдрүүдтэй холбогдуулан 2020 оны 12 сарын 29-ны өдрөөс 2021 оын 01 сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд зоонозын халдварт өвчний дуудлагын бэлэн байдлыг хангаж ажиллах дуудлагад үйлчлэх баг, хариуцлагатай жижүүрийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын дуудлага, хяналтын жижүүр эмчтэй хоёр цаг тутам холбогдон мэдээлэл авч, жижүүрийн хугацаанд нэг удаа байгууллага дээр ирж дуудлага, хяналтын бага эмчийн үйл ажиллагаа болон дуудлагын бэлэн байдал, цахилгаан, дулаан, гадна орчны аюулгүй байдалд хяналт тавьж, Эрүүл мэндийн яамны хариуцлагатай жижүүрт мэдээлэл өгч ажиллахыг хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.

3. Цаг үеийн байдалтай холбоотой, яаралтай шийдвэрлэх асуудал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, зоонозын халдварт өвчний яаралтай дуудлага гарсан үед төвийн ерөнхий захирал, дэд захирал, захиргааны албаны дарга болон холбогдох албаны дарга нарт шуурхай мэдээлж, мэргэжлийн багийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Дуудлагын баг, Дуудлага хяналтын жижүүрүүдэд тус тус даалгасугай.

4. Яаралтай дуудлагын үед шаардагдах багаж, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, утасны карт, шатахуун, тослох материал, цахилгааны нэмэлт эх үүсвэрээр хангах, дулаан хангамжийн найдвартай байдал, гал түймэр аваар ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч автомашинуудын бэлэн байдлыг хангаж ажиллахыг Аж ахуй хариуцсан менежер /Б.Батжаргал/-т даалгасугай.

5. Ажлын өрөөний хаалгыг журмын дагуу лацдан түлхүүрийг дуудлага хяналтын бага эмчид хүлээлгэн өгөх, гар утсаа байнга нээлттэй байлгах, шаардлагатай үед дуудагдан ажиллахыг нийт ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга /Ц.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий
захирлын 2020 оны 12 дугаар сарын 28 - ны
өдрийн 4/01 дугаар тушаалын хавсралт

ШИНЭ ЖИЛИЙН АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮР
ХИЙХ АЛБАН ХААГЧДЫН ХУВААРЬ

№		XII/29	XII/30	XII/31	I/01	I/02	I/03
1	Д.Алтантогтох						
2	Ц.Энхбаяр						
3	У.Нармандах						
4	Д.Отгонбаяр						
5	З.Ууганцэцэг						
6	А.Амгаланбаяр						

ДУУДЛАГА ХЯНАЛТЫН ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Нэрс	XII/29	XII/30	XII/31	I/01	I/02	I/03
1	Л.Насанхишиг						
2	Я.Ягаанхүү						
3	П.Шийлэгбат						
4	Г.Мишигдорж						

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 12 дугаар сарын 28 - ны өдрийн 4/101 дугаар тушаалын хавсралт

12 САРЫН ДУУДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Албан тушаал	Нэр	Утас
1	Тархвар судлагч	Ш.Сувд-Эрдэнэ	89972818
2	Эмнэлзүйч эмч	С.Оюунчимэг	99724590
3	Генетикч	Х.Тунгалаг	88028821
4	Нян судлагч эмч	Б.Бямбажав	99710480
5	Нян судлалын лаборант	Ч.Отгонсүрэн	80800310
6	Биологич	С.Отгонжаргал	88000686
7	Ариутгагч	П.Дэлгэрмаа	88046465
8	Бэлдмэлчин	Л.Энхтуяа	94272838 94092838
9	Жолооч	П.Түвшинзаяа	91940331

2021 ОНЫ 01 САРЫН ДУУДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Албан тушаал	Нэр	Утас
1	Тархвар судлагч	Г.Ганбилэг	96007732
2	Биологич	М.Байгалмаа	89545869
3	Эмнэлзүйч эмч	С.Оюунчимэг	99724590
4	Нян судлагч эмч	Г.Ганзориг	99814172
5	Лаборант	Ц.Батөлзий	99944036
6	Жолооч	Ч.Лхагвасүрэн	99753973
7	Ариутгагч	М.Нарантуяа	88031109
8	Бэлдмэлчин	Б.Саранчимэг	99781511